

10 сарын 16, Даваа 10:16:08

АЛТАЙ 1°C | EUR 2910.74


[ЭХЛЭЛ](#) | [УЛСТӨР](#) | [ЭДИЙН ЗАСАГ](#) | [ШИЛДЭГ](#) | [БУСАД](#) ▾ |

Ботаникт эмнэлэг, сургуулийн цогцолбор сүндэрлэнэ

[Б.ТУУЛ](#)
[1 ЦАГ 25 МИНУТЫН ӨМНӨ](#)

ЗУУНЫ МЭДЭЭ



Жилийн дөрвөн улирлын аль ч өдрүүдэд хөл ихтэй утдаг, ачааллаа дийлэхгүй шахам ажилладаг газар бол дүүргүүдийн эмнэлэг. Ялангуяа, хүйтэн сэруүний улиралд ор тасгийн хүрэлцээ хангамж ярьж, хонгил дүүрэн хүн хэвтэж эмчлүүлдэг. Улсын гурав дахь шатлалын эмнэлгүүдээс ч бас энэ дүр зургийг харж болно. Тэгвэл эдийн засгийн хямралтай энэ үед төр, засгийн нуруун дээрх энэ хүнд ачааг гаднын зээл тусламж, төсөл хөтөлбөрүүд хөнгөлдөг гэхэд буруудсан болохгүй.

Тэр тусмаа Япон улсаас хэрэгжүүлж буй олон төсөл хөтөлбөрийг онцлох хэрэгтэй байх. 2017 оны гуравдугаар сарын байдлаар Япон улсаас нийт 504 төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна. Эдгээрээс хамгийн их хүлээлт дагуулж буй нь бидний "мөнхийн

СЭДВС-ийн Монголийн ачааллыг хөнгөвчлөх, II дэхь шаталын 985 эмнэлгийн узүүлэлтэйгээг үзүүлэх, Монгол-Японы хамтарсан сургалтын бааз эмнэлэг барих төсөл юм.

Монгол Улсад анх удаа баригдаж буй анагаахын сургуульд түшиглэсэн энэ эмнэлгийг 2018 оны долоодугаар сард Монголын талд түлхүүр хүлээлгэн егех нөхцөлтэйгөөр барьж байгаа билээ. Тиймээс бид энэ удаа Япон улсын ЭСЯ-тай хамтран Монгол Улсад хэрэгжүүлж буй тусlamжийн хөтөлбөрүүдээс онцлон АШУҮИС-ийн сургалтын эмнэлгийн барилгын ажлын явц, үйл ажиллагаатай танилцсан юм.

“СУРГАЛТЫН ЭМНЭЛГИЙГ ЕСӨН САРЫН ДАРАА ХҮЛЭЭЖ АВНА”

Биднийг очиход АШУҮИС-ийн захирал Г.Батбаатар болон холбогдох албаны хүмүүс тодорхой мэдээллүүдийг өгсөн юм. “Монгол-Японы сургалтын бааз эмнэлгийг барих төсөл амжилттай хэрэгжсэнээр олон улсын стандартад нийцсэн эмнэлгийн тусlamж үйлчилгээг иргэдэд хүргэнэ. Мөн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн эмч нарыг бэлтгэх боломж бүрдэнэ” гэдгийг албаныхан онцолж байв. Япон улсаас хэрэгжүүлж буй энэ тусlamжийн хөтөлбөр нь дан ганц эмнэлгийн барилгыг барьж өгөхөөр хязгаарлагдахгүй юм байна.

Энэ төсөл нь Монголд анхны их сургуулийн эмнэлгийг барьж байгуулахаас гадна тус эмнэлэгт хэрэг болох тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх, эмнэлгийн дотоод зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох, эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулах, мэргэшүүлэх гээд бүх талын тусlamж үзүүлэх ажээ. Төслийн нийт өртөг 7 тэрбум 985 иен буюу ойролцоогоор 174 тэрбум 400 сая төгрөгийн бүтээн байгуулалтын ажил ид өрнөж байна.

Одоо эмнэлгийн барилгыг хүлээж авахад есөн сарын хугацаа үлдээд байгаа аж. Хүйтэн сэргүүний улирал гэж цаг алдалгүй, бүхий л ажил технологийн дагуу, стандарт шаардлага, жилийн төлөвлөгөөний дагуу урагшилж байгаа г барилгын ажил удирдсан дарга нар хэлж байсан юм. Сургалтын бааз эмнэлэг нь зохион байгуулалтын хувьд, 150 ортой байхаар төлөвлөгдсөн байна.

Их сургуулийн эмнэлгийн хэтийн зорилго нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах. Тиймээс дотрын тасаг, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүд, яаралтай тусlamж, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг бүгд байхаар төлөвлөсөн гэдгийг албаныхан дуулгав.

АШУҮИС нь сургалтын бааз эмнэлэгтэй болсноор сургалтын чанар, төгсөгчдийн чанарыг дээшлүүлэх, анагаахын сургууль нь дан ганц оюутны төлбөрөөр санхүүждэг бус санхүүжүүлэх өөр эх үүсвэрүүдийг эрэлхийлэх гээд олон шинэ боломжууд бүрдэж байгааг албаны хүмүүс хэлж буй. Энэ талаар зарим хүний сэтгэгдлийг сонссон юм.

10 сарын 19 ЖИЛД 192 МЯНГАН ХҮНД ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ УЗУУЛНЭ 2910.74

АШУУИС-ийн захирал Г.Батбаатар:

-Уг төсөл хэрэгжсэнээр АШУУИС нь анагаах ухааны ололт амжилтыг нэвтрүүлсэн үндэсний шилдэг эмнэлэгтэй болох боломж бүрдэж байгаа юм. Дэлхийн шилдэг эмнэлгүүдэд ашиглаж байгаа хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжүүдэд суурилсан үйлчилгээг хүн амд хүргэнэ. Амбулаториор өдөрт 600, жилд 192 мянган хүнд эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлнэ гэсэн тооцоог бид гаргасан.

Хэвтэн эмчлүүлэхээр 4,300 орчим хүнд үйлчилж, ойролцоогоор 2,300 орчим мэс засал, 10 гаруй мянган дүрс оношилгооны ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Цаашид эмнэлгийн үйл ажиллагаа тогтвортожиж, эмчилгээ үйлчилгээний төрөл өргөсөх тусам энэ эмнэлгээр үйлчлүүлэх үйлчлүүлэгчдийн ТОО нэмэгдэнэ.

Эмнэлгийн барилгын ажилд "Yamashita Sekkei" INC, Azusa Sekkei., LTD хоёр барилгын компани маш сайн хяналт тавин ажиллаж байна. Бүх ажил төлөвлөгөөний дагуу явж байна.

ЗУУНЫ МЭДЭЭ Цээлээс олоогүй бичнэ
Үндэсний одбор тутмын сонин

**2017 ОНЫ II УЛИРЛЫН
ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ**

315589 @ zuunimedee@yahoo.com

Таалагдлаа 44

Хуваалцах

Илгээх

Facebook-т хадгалах

ЭНЭ МЭДЭЭНД ӨГӨХ ТАНЫ ХАРИУЛАЛ?

4

